



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/273

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам"-ын 5.6.2 дахь заалт, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 100 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 2/16938 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сувилагч Өлзийдорж овогтой Алтансүвд /регистрийн дугаар ВЮ83090521/-ын МС0015122 сери, 0015122 дугаарын сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаагаар хүчингүйд тооцсугай.

2. Сувилагч Ө.Алтансүвдын сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр жилийн хугацаагаар хүчингүй болгосныг эмнэлгийн мэргэжилтний мэдээний санд бүртгэн, нийтэд мэдээлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дарга /Д.Цэрэндагва/-д тус тус даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

D:\barimt\tushaal

080866